

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын
2011 оны А/74 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

МАЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ" ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад үржүүлж байгаа малыг ялган тэмдэглэх, тэдгээрийн удам гарваль, ашиг шим, үржил, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг бүртгэлд авах, шилжилт хөдөлгөөнийг хянах, бүртгэлийн анхан шатны өгөгдлийг мэдээллийн нэгдсэн санд оруулах, боловсруулах, дамжуулах, ашиглах зэргээр мал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын баталгааг бүртгэлээр дамжуулан хянах, тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Энэхүү журмын хүрээнд "мал" гэсэн нэр томъёог Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 1.1-д зааснаар ойлгоно.

ХОЁР.МАЛЫГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭХ ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ

2.1.Ялган тэмдэглэх хэрэгслийн төрөл, стандарт, түүнд тавигдах шаардлага

2.1.1.Малын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхийн тулд тухайн төрлийн малд тодорхой нэгэн ялган тэмдэглэгээг заавал хийсэн байна;

2.1.2.Ялган тэмдэглэгээг тухайн малын биед сөрөг нөлөөгүй, зориулалтын аль нэгэн төрлийн ялган тэмдэглэх хэрэгслийг байршуулах замаар хийнэ;

2.1.3.Малыг ялган тэмдэглэх хэрэгсэл нь Олон Улсын ISO стандарт болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлагыг хангасан байна;

2.1.4.Энэхүү журмын хүрээнд мал, малын эзэн, малчны байршил Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стандарт /MNS 5641:2006/-ын дагуу кодлогдоно;

2.1.5.Малыг ялган тэмдэглэх хэрэгсэл дээр бичигдэх дугаар нь дахин давтагдахааргүй байх ба улсын кодын "MN" гэж товчилсон 2 үсгийг ялгах хувийн дугаарын өмнө бичнэ;

2.1.6.Малыг ялгах хувийн дугаар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стандартад заасан аймаг, сум, багийн 6 орон, тухайн малыг ялгах хувийн дугаарыг заасан 6 орон, нийт 12 оронтой тоогоор энэхүү дарааллаар тэмдэглэгдэн бичигдэнэ;

2.1.7.Энэхүү журмын хүрээнд малыг ялган тэмдэглэх хэрэгслийн нэг болох ээмэг нь уян хатан, гадны нөлөөнд тэсвэртэй, өндөр чанарын полиуретан материалаар хийгдсэн байх ба үйлдвэрлэгч нь материалын чанарыг холбогдох мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсан байх ёстой;

2.1.8.Ээмэг дэх тэмдэглэгээг лазер технологиор арилахааргүй бичих ба хэвлэмэл тэмдэгтийг бар кодыг унших тусгай төхөөрөмж ашиглан таниулна;

2.1.9.Энэхүү журмын хүрээнд малыг ялган тэмдэглэх хэрэгслийн нэг болох чип нь тусгай зориулалтын биобүрхүүл бүхий ариутган битүүмжилж тариурт байршуулсан, ISO 11784, ISO 11785 стандартын шаардлагыг хангасан FDX-B технологитой, пассив хаягтай байна;

2.1.10.Радио долгионы давтамж, өгөгдөл дамжуулах хурд нь журмын 2.1.9-д заасан стандартын шаардлагыг хангасан байна;

2.1.11.Ялган тэмдэглэгээний кодыг уншигч төхөөрөмж нь ялган тэмдэглэгээний хэрэгсэл дээр байгаа дугаарыг нэгдсэн программд хувирган унших, дамжуулах чадвартай байна;

2.1.12.Нэмэлт программыг суулгах боломжтой уншигчийг ашиглах тохиолдолд оруулах өгөгдлүүдийг мэдээллийн сангийн бүтэцтэй уялдуулсан байна;

2.1.13.Баркод унших төхөөрөмжийн чадварын үнэлгээг ялган тэмдэглэгээний 50-иас доошгүй хэрэгсэлд, хэвлэлтийн чанарын урьдчилсан үнэлгээг 20-иос доошгүй хэрэгсэлд тус тус явуулж, нэг хэрэгсэлд дээд тал нь 4 удаагийн унших оролдлого хийхэд унших ажиллагаа нь 95%-иас дээш байвал хангалттай ажиллагаатай гэж үзнэ;

2.1.14.Ээмэглэгч нь тухайн ээмэгтээ тохирсон, чанар нь стандартаар баталгаажсан, хэрэглэхэд хөнгөн, авсаархан, аятай байх нөхцлийг хангасан байна;

2.1.15.Малын ялгах тэмдэг гээгдсэн, гэмтсэн, баларсан тохиолдолд малын эзэн нь 30 хоногийн дотор харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт мэдэгдэнэ;

2.1.16.Гээгдсэн, гэмтсэн ялган тэмдэглэх хэрэгслийн дугаарын өөрчлөлтийн тэмдэглэгээг бүртгэлийн мэргэжилтэн тухай бүрт хийж, мэдээллийн сангийн архивт хуучин дугаарыг хадгалан мэдээллийг үргэлжлүүлэн хөтлөнө;

2.1.17.Нэг орноос өөр нэг оронд импортолж буй малыг анх ирсэн дугаар, нэр хочоор үргэлжлүүлэн хөтлөх боломжгүй тохиолдолд тэмдэглэгээг шинэчлэн хийнэ;

2.1.18.Гадаадаас импортолсон малын ялган тэмдэглэгээг өөрчлөх шаардлагатай болсон тохиолдолд албан ёсны бүртгэлд анхных нь дугаар, нэр хочийг заавал тэмдэглэнэ. Мөн томоохон үзэсгэлэн, худалдааны каталогиуд, гэрчилгээнд анхны дугаар, нэр хочийг давхар тэмдэглэнэ;

2.1.19.Малын удам зүйн өгөгдлийг боловсруулах, биржийн харилцаанд оролцох зэрэг тохиолдолд бүртгэлийн системд мал, сүргийг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан кодоор тэмдэглэж байна;

2.1.20.Малын хувийн дугаар буюу кодыг дараахь баримт, бичгүүдэд заавал бичиж байна. Үүнд:

- малын удам гарваль, байршил тодорхойлохтой холбоотой гэрчилгээ, бусад баримт бичиг;
- малын эрүүл мэндийн талаархи баримт бичиг;
- малын гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн тодорхойлолт;
- лабораторийн дүн шинжилгээний тодорхойлолт;
- малын даатгалын баримт бичиг;
- малыг худалдах болон худалдан авахтай холбогдолтой баримт бичиг;
- малын шилжилт хийсэн тодорхойлолт;
- малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт гэх мэт.

2.1.21.Малын ялган тэмдэглэгээг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, өөрчлөлт оруулах, хайлт хийх ажлыг нэгдсэн программын тусламжтайгаар гүйцэтгэнэ;

2.1.22.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн программыг энэхүү журмын 2 дугаар хавсралтад "Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц"-ийн дагуу боловсруулж, босоо ба хөндлөнгөөр өргөтгөх боломжоор хангаж байна.

2.2.Бод малыг ялган тэмдэглэх хэрэгсэл, түүнийг хэрэглэх

2.2.1.Бод малд үхэр, тэмээ, адуу хамаарна;

2.2.2.Энэхүү журмын хүрээнд бод малыг ялган тэмдэглэх хэрэгсэл нь үхэр, тэмээнд ээмэг, адуунд чип бүхий тариур, түүний дагалдах хэрэгслүүд байна;

2.2.3.Бод малын ээмэгний хийц, загвар нь доор тодорхойлсны дагуу байна:

- ээмэг нь эр, эм гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Эм талын хэсэгт эр талыг салгахгүй байх зориулалт бүхий ховил, эр талын үзүүр хэсэг металл байна;
- ээмэгний өндөр нь 70 мм – 85 мм;
- ээмэгний өргөн хэсэг 55 мм – 65 мм;

- ээмгэнд бичигдэх үсэг, тооны өндөр 10 мм -14 мм;

- бар кодын өндөр 8 мм -9 мм;

- бар кодын бичилтийн хоёр үзүүрт байх зах хэсэг нь 5 мм-7 мм байна.

2.2.4.Энэхүү журмын хүрээнд адууг ялган тэмдэглэх хэрэгсэл нь уламжлалт тамгаас гадна арьсан дор суулгахад зориулагдсан, биобүрхүүл бүхий ариутган битүүмжлэгдсэн, тариурт байршуулсан, радио долгионы давтамжаар мэдээлэл дамжуулах пассив хаягтай чип байна;

2.2.5.Чипний урт 13,0 мм–ээс, диаметр 2,5 мм-ээс ихгүй байна;

2.2.6.Чипэнд бичигдэх дугаар энэхүү журмын 2.1.4-2.1.6 зүйлд заасны дагуу дахин давтагдахгүй байна;

2.2.7.Энэхүү журмыг хэрэгжиж эхлэхээс өмнө ялган тэмдэглэгээ хийгдсэн малын дугаарыг "хуучин дугаар" гэж бүртгэлд тэмдэглэн, нэгдсэн программд хувиргаж хэрэглэх тохируулга хийнэ;

2.2.8."Хуучин дугаар"-ын бүртгэлийг энэхүү журмын 6 дугаар хавсралтаар тодорхойлсон маягтын дагуу бүртгэгч хөглөн, харъяаллын мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө;

2.2.9.Мэдүүлгийг хүлээн авсан мэргэжилтэн энэхүү журмын холбогдох заалтуудад нийцүүлэн тухайн малын мэдээллийг нэгдсэн программд оруулан бүртгэлд авна;

2.3.Бог малын ялган тэмдэглэх хэрэгсэл, түүнийг хэрэглэх

2.3.1.Бог малд хонь, ямаа хамаарна;

2.3.2.Энэхүү журмын хүрээнд бог малыг ялган тэмдэглэх хэрэгсэл нь бар код бүхий ээмэг, түүний дагалдах хэрэгслүүд байна;

Бог малын ээмэг нь дор дурьдсан хэмжээ загвартай байна. Үүнд:

- ээмэг нь эр, эм гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Эм талын хэсэгт эр талыг салгахгүй байх зориулалт бүхий ховил байна;

- ээмэгний өндөр 40 мм – 50 мм;

- ээмэгний өргөн 33 мм-38 мм;

- ээмгэнд бичигдэх үсэг, тооны өндөр 5 мм -7 мм;

- бар кодын өндөр 6 мм -7 мм;

- баркодын бичилтийн хоёр үзүүрт байх зах хэсэг нь 2 мм -3 мм байна.

2.3.3.Энэхүү журмын 2.2.7-д тодорхойлсон нөхцөл үүссэн тохиолдолд хариу авах арга хэмжээ тус заалттай ижил байна.

2.4.Тэжээвэр амьтныг ялган тэмдэглэх хэрэгсэл, түүнийг хэрэглэх

2.4.1.Энэхүү журмын хүрээнд амьтан гэсэн тодорхойлолтонд цаа буга, гахай, шувуу, нохой, муур зэрэг тэжээвэр амьтдыг багтаана;

2.4.2.Цаа бугыг ялган тэмдэглэх хэрэгсэл нь энэхүү журмын хүрээнд баркод бүхий ээмэг, түүний дагалдах хэрэгслүүд байна;

2.4.3.Ээмэгний хийц, загвар нь энэхүү журмын 2.2.3-д тодорхойлсон үзүүлэлтийг хангасан байна;

2.4.4.Гахайг ялган тэмдэглэх хэрэгсэл нь энэхүү журмын хүрээнд баркод бүхий ээмэг, түүний дагалдах хэрэгслүүд байна;

2.4.5.Ээмэгний хийц, загвар нь энэхүү журмын 2.3.2-д тодорхойлсон үзүүлэлтийг хангасан байна;

2.4.6.Шувууны төрлөөс тахиа, галуу, нугас, цацагт хяруул зэрэг амьтдын ялган тэмдэглэгээг чип бүхий тариур ашиглан эсвэл бөгжлөн хийж болно;

2.4.7.Нохой, муур зэрэг амьтдын ялган тэмдэглэгээг чип бүхий тариур ашиглан хийж болно;

2.4.8.Гахай, шувуу, нохой, муурын нарийвчилсан бүртгэлийг тухайн эзэн хариуцан хийх ба нэгтгэлийг мэргэжлийн төрийн бус байгууллага нь хийж шаардлагатай мэдээллийг төв сервер буюу малын бүртгэл, мэдээллийн үндэсний санд дамжуулна;

2.4.9.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд гахай болон шувууны бүртгэлийг сүргээр нь хийж, сүргийн үүлдэр, байршил, эзнийг кодлон бүртгэнэ.

2.5.Малыг ялган тэмдэглэх хэрэгслийг захиалах, нийлүүлэх

2.5.1.Малыг ялган тэмдэглэх хэрэгслийн тухайн жилийн хэрэгцээ, төрлийг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг тооцоолон захиалгыг аймаг, нийслэлийн мал үржлийн албанд ирүүлэх ба тус алба нь захиалгыг нэгтгэн төв сервер буюу малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн санд ирүүлнэ;

2.5.2.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан нь орон нутгаас ирүүлсэн захиалгад үндэслэн тухайн жилд шаардагдах ялган тэмдэглэх хэрэгслийн нийт хэмжээ, төрөл, түүн дээр бичигдэх дугаарыг гарган ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч, нийлүүлэгчид захиалга өгнө.

2.5.3.Малыг ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч нь Олон Улсын Мал, амьтны бүртгэлийн хорооноос хүлээн зөвшөөрөгдөж код авсан үйлдвэрлэгч байна;

2.5.4.Нийлүүлэгч нь энэхүү журмын 2.5.3 зүйлд заасан албан ёсны үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэгтэй бөгөөд ялган тэмдэглэх хэрэгслийн чанар, хийц, загвар нь энэхүү журмын 2.1.3, 2.2, 2.3, 2.4 зүйлд зааснаар тодорхойлогдоно;

2.5.5.Малыг ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэхүү журмын 2.1.3-2.1.14, 2.2.3-2.2.6, 2.3.2 зүйлд заасан шаардлагыг хангасан хэрэгслийг захиалагчид нийлүүлнэ;

2.5.6.Малыг ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь ялган тэмдэглэгээний хэрэгслийн үйлдвэрлэл болон нийлүүлэлт хийхийн өмнө ялган тэмдэглэх хэрэгсэл дээр бичигдэх сериал дугаарыг энэхүү журмын 2.5.2 зүйлд заасан нэгжээс авсан тохиолдолд нэгдсэн бүртгэлд орох боломж бүрдэнэ;

2.5.7.Ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нь захиалгаар үйлдвэрлэсэн ба нийлүүлсэн ялган тэмдэглэх хэрэгсэлийн гарал үүсэл, нэр төрөл, серийн дугаар, тоо хэмжээг бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн санд тухай бүрт албан ёсоор ирүүлэх, нийлүүлсэн бүтээгдэхүүний чанарыг бүрэн хариуцаж, гэмтэл согогийг тухай бүрт арилгах үүргийг хүлээнэ;

2.5.8.Малын ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нь малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сантай ялган тэмдэглэх хэрэгслийн дэвшил, хөгжлийн талаар санал солилцох, хамтран ажиллана;

2.5.9.Ялган тэмдэглэх хэрэгслийг мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд малд байршуулж, энэхүү журмын 3 (3.1-3.5) дугаар хавсралтаар тодорхойлсон гэрчилгээг тухайн төрлийн мал тус бүрт хөтлөн малын эзэн эсвэл малчинд хүлээлгэн өгнө;

2.5.10.Малд ялган тэмдэглэгээ хийж гэрчилгээ олгосон тухай баталгаажуулалтыг энэхүү журмын 5 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу 3 хувь үйлдэж, малчны гарын үсгээр баталгаажуулан, хувийг малчинд болон сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлийн мэргэжилтэнд өгч, үлдсэн хувийг нэгжийн архивт хадгална;

2.5.11.Малд ялган тэмдэглэх хэрэгслийг байршуулан, гэрчилгээг олгогч нь хүлээсэн үүргийнхээ дагуу тэмдэглэгээ хийж бүртгэлд авсан малын төрөл, тоо, байршил, ялган тэмдэглэх хэрэгслийн төрөл, серийн дугаар, гэрчилгээний дугаар зэргийг харъяалах бүртгэл мэдээллийн албанд сар бүрийн 15-нд албан ёсоор мэдэгдэж, холбогдох баримтын хувийг хүлээлгэн өгнө.

ГУРАВ.МАЛЫН ҮР, ХӨВРӨЛ ҮРИЙГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭХ

3.1.Малын үрийг ялган тэмдэглэх

3.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрөл бүрийн малын шилмэл хээлтүүлэгчээс үр авч шингэлэн гүн хөлдөөх тохиолдолд тухайн үрийн гуурс тус бүр дээр энэхүү журмын 3.1.2-д заасны дагуу ялган тэмдэглэгээг заавал хийнэ;

3.1.2.Тэмдэглэгээ нь улсын код, байгууллагын код, тухайн малын үүлдрийн код, хээлтүүлэгчийн хувийн дугаар, үр авсан огноо, үрийн серийн дугаар гэсэн дараалалтайгаар бичигдэнэ;

3.1.3.Үр авах, бэлтгэх, хөлдөөх, түүнийг түгээх эрх бүхий байгууллага нь хээлтүүлэгчээс үр авах ариун цэвэр эрүүл ахуй, биоаюулгүй байдлын шаардлагыг зохих журам, зааврын дагуу хангасан, үрийг авах, бэлтгэх, ичээх, гүн хөлдөөх, хадгалах, тээвэрлэх чиглэлээр мэргэшин хүлээн зөвшөөрөгдсөн, удирдлага, хяналттай байгууллага байна;

3.1.4.Монгол улсын нутаг дэвсгэр дээр цэвэр үүлдэр, омгийн малын хээлтүүлэгчээс үр авах, бэлтгэх, хөлдөөх, түүнийг түгээх төв байгууллага болон энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах бусад байгууллагууд нь энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу тодорхойлон кодлогдоно;

3.1.5.Малын үүлдэрлэг байдал, сүргийн кодыг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу бүртгэнэ. Үүлдрийн болон сүргийн кодыг дангаар нь эсвэл нэг бүрдэл тэмдэглэгээ байдлаар хэрэглэж болно. Шаардлагатай тохиолдолд хавсралтанд нэмэлт оруулах замаар тэмдэглэгээг нэмж болно;

3.1.6.Хээлтүүлэгчийн хувийн дугаар нь энэхүү журмын 2.1.5- 2.1.6 дугаар зүйлд заасны дагуу ялган тэмдэглэгдсэн байна;

3.1.7.Үр авсан огноог **YY/00.XX** гэсэн формат хэлбэрээр хэвлэнэ. Үүнд: YY/ - тухайн оны сүүлийн 2 орон (10 эсвэл 11 гэх мэт) ташуу зураас, 00 - тухайн сарын 2 орон (05 эсвэл 12 гэх мэт) цэг, XX – тухайн өдрийн 2 орон (08 эсвэл 25 гэх мэт) байна;

3.1.8.Үрийн серийн дугаарыг нэмэгдэл мэдээлэл гэж үзэх бөгөөд хэвлэхдээ тухайн огнооны дараа ташуу зураасаар зааглан нэмж оруулна. Үүнд: "**YY/00.XX/15**" гэх мэт;

3.1.9.Үрийн гуурсан дээрх хэвлэлт нь мэдээллийг харагдахуйц тод байлгах нөхцлийг хангасан байх ёстой;

3.1.10.Үрийн гуурсан дээрх тэмдэглэгээнээс өгөгдлийн санд "үр бэлтгэгчийн улс орны гарал, хээлтүүлэгчийн үүлдэр, хувийн дугаар" зэргийг онцлон үзэх бол малын үржүүлгийн техникч "хээлтүүлэгчийн үүлдэр, хувийн дугаар, үр бэлтгэсэн огноо, серийн дугаар"-ыг онцлон тэмдэглэж авна;

3.1.11.Үрийн гуурсан дээр тэмдэглэсэн кодыг тухайн төрлийн малын үүлдэр олон улсын кодын жагсаалтад орсон эсэхээс хамааран улсын гарал үүсэл болгон шууд хэрэглэж болно;

3.1.12.Олон улсын жагсаалтад орсон үүлдэртэй нэр давхардахгүй, бие даасан үүлдэр болох нь тогтоогдсон үүлдрийн шилмэл хээлтүүлэгчээс 10000-аас доошгүй тун үрийг 3-аас дээш

оронд экспортолсон тохиолдолд тухайн үүлдрийг олон улсын ялган тэмдэглэгээний кодын жагсаалтад гарал үүслийн орноор бүртгүүлэх хүсэлтийг Олон улсын мал, амьтны бүртгэлийн хороонд албан ёсоор холбогдох журмын дагуу гаргаж болно;

3.1.13. Дээрх тоо нь олон улсын шинэчлэгдсэн журмын дагуу өөрчлөгдөж болно;

3.1.14. Олон улсын үүлдрийн кодын жагсаалтад үүлдрийн гарал үүслийг өөрийн орноор бүртгүүлсэн тохиолдолд тухайн үүлдрээс үйлдвэрлэсэн үрийн тунгийн тоо, экспортод гаргасан тунгийн тоо зэрэг удамшил зүйн материалын талаар олон улсын хэмжээнд харилцан солилцох үүрэг хүлээнэ.

3.2. Малын хөврөл үрийг ялган тэмдэглэх

3.2.1. Янз бүрийн нөхцөл байдлын улмаас хөврөл үрийн гарал үүсэлтэй холбоотой түүхийг мөшгин судлах, ашиглах, мэдээллийн санг бүрдүүлэхэд хэрэглэх зориулалтаар малын хөврөл үрийн талаарх мэдээллийг заавал бүртгэнэ;

3.2.2. Хөврөл үрийн гуурс тус бүр дээр тухайн хөврөл үрийн талаархи мэдээллийг харуулсан лавлагаа дугаарыг хэвлэсэн байна;

3.2.3. Лавлагаа дугаарт тухайн хөврөл үрийг бэлтгэсэн байгууллагын код, гардан гүйцэтгэгч багийн ахлагчийн код, хөврөл үрийг угааж авсан хээлтэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хөврөл үрийг бүрдүүлэгч хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хөврөл үрийг бэлтгэсэн он, сар, өдөр, хөврөл үрийн серийн дугаар, хөврөл үрийн нас, хөлдөөлтийн огноог тус тус бичнэ;

3.2.4. Лавлагаа дугаарт тухайн захиалагч болон үржүүлгийн байгууллагын шаардлагаар өөр бусад мэдээлэл нэмж оруулж болно;

3.2.5. Хөврөл үрийг угааж авах, хөлдөөх үед уг ажиллагааг ахлан гүйцэтгэгчийн талаархи тодорхойлолтыг тусгайлан авч бүртгэн, код олгоно;

3.2.6. Төрөл бүрийн малын хөврөл үрийг зайлж авах, хөлдөөх, шилжүүлэн суулгах ажиллагааг мэргэшсэн эрдэмтэд, судлаачид, мал зүйч, малын эмч, нөхөн үржүүлгийн техникч нар дангаар эсвэл багаар гүйцэтгэх бөгөөд багийн ахлагч лавлагаа бүртгэлээ төрийн захиргааны төв байгууллагад өгч, кодоо авна;

3.2.7. Гардан гүйцэтгэгч багийн ахлагчийн код нь харъяаллын байгууллагын кодын дараа бичигдэнэ;

3.2.8. Хөврөл үрийн гарал үүсэлтэй холбоотой мэдээллийн санд хөврөл үрийг бэлтгэсэн донор хээлтэгч, хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, ашиг шимийн үзүүлэлт, хөврөл үрийг угааж бэлтгэсэн, хөлдөөсөн, генийн санд хадгалсан, импортолсон, ашигласан огноо, тээгчид шилжүүлэн суулгасан огноо, хөврөлийн нас, хөврөл үрийг шилжүүлэн суулгасан ажилбарын төрөл, тээгчийн хувийн дугаар зэрэг өгөгдлийг бүртгэнэ;

3.2.9.Хөврөл үрийг экспортлох зорилгоор гарган авсан нөхцөлд ялган тэмдэглэгээг Мал, амьтны бүртгэлийн Олон улсын хорооноос гаргасан үүлдрийн кодын жагсаалтын дагуу хийнэ;

3.2.10.Тухайн жагсаалтад ороогүй үүлдрийн малаас хөврөл үр бэлтгэж буй тохиолдолд энэхүү журмын 2.1.5, 2.1.6-д заасны дагуу ялган тэмдэглэгээг хийнэ;

3.2.11.Импортлосон хөврөл үртэй холбоотой өгөгдлүүдийг дагалдах баримт бичигт үндэслэн авах ба хөврөл үрийг импортлох, борлуулах үед цаасан болон цахим мэдээлэлд байгаа үзүүлэлтийг хөврөл үрийн гуурсан дээрхи тэмдэглэгээтэй харьцуулан үзэж гарал үүслийг баталгаажуулна;

3.2.12.Хөврөл үр шилжүүлэн суулгах замаар гарсан төлийн гарвацийг тодорхой болгохын тулд удамшлын эх болон биологийн эх хоёрын хоорондох ялгааны бүртгэлийг хөврөл үр шилжүүлэн суулгах үед холбогдох баримт бичигт заавал тэмдэглэнэ;

3.2.13.Хөврөл үрийг угааж авах, хөлдөөх, хадгалах, шилжүүлэн суулгах зэрэг ажилбар бүрийн гүйцэтгэсэн огноог анхан шатны бүртгэлд тэмдэглэж байна;

3.2.14.Хөврөл үр бэлтгэн авах, шилжүүлэн суулгахад ашиглагдах донор болон тээгч малыг шилэн сонголтын үндсэн дээр сонгож, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн тусгай нөхцөлд тэжээллэг, арчилгаа маллагааны технологийн дагуу байлгана;

ДӨРӨВ. МАЛЫГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1.Малын удам гарвацийн талаарх мэдээллийг бүртгэх, хянан баталгаажуулах

4.1.1.Бүртгэл хариуцсан байгууллага нь тухайн малын удам гарвацийн талаар бүртгэлийг бүртгэл хөтлөгчөөс мэдээлэл авах замаар явуулна;

4.1.2.Бүртгэл хөтлөгчид нь тухайн сум, дүүргийн мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтэн, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн малын үржүүлгийн техникч, малын эмч, мал зүйч, малчид байна;

4.1.3.Ялган тэмдэглэх хэрэгсэл байршуулсан малын бүртгэлийг хийхдээ төрсөн улс орны кодыг үсгэн 2 тэмдэгтээр, засаг захиргааны нутаг дэвсгэрийн байршлыг 6, өрхийн кодыг 4, тухайн малын төрлийг 2, үүлдрийн кодыг 3, хувийн дугаарыг 12, хүйсийн кодыг 1 тэмдэгтээр тус тус тэмдэглэнэ;

4.1.4.Малын үүлдэрлэг байдлыг малын бүртгэлийн гэрчилгээн дэх удам гарвацийн бүртгэл, ангилалтын үнэлгээг үндэслэн тогтооно;

4.1.5.Малын удам гарвацийг тухайн мал тус бүрт хөтөлсөн бүртгэлийн гэрчилгээний үзүүлэлтүүд болон мэдээллийн санд ирүүлсэн холбогдох өгөгдлүүдэд үндэслэн тогтооно;

4.1.6.Малын удам гарвалийн талаарх мэдээллийг албан ёсны гэж үзэхээс өмнө дараах энгийн магадлалыг хийнэ. Үүнд:

- хээлтэгч, хээлтүүлэгч мал нь зохих ёсны ялган тэмдэглэгээний дугаартай эсэх;
- хээлтэгчийн төллөсөн өдөр нь үржүүлгийн огноо болон тухайн үүлдрийн малын хээл тээх дундаж хугацаанаас ± 10 өдрийн дотор багтаж байгаа эсэх;
- хээлтэгч нь үржүүлгийн үед тухайн малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж дээр байсан эсэхийг хянах;
- тухайн малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж хээлтүүлэгчтэй байсан эсэхийг хянах;

4.1.7.Малын удам гарвалийн нарийвчилсан хянан баталгааг хийхдээ тэдгээрээс цусны эсвэл эд, эсийн дээж авч, цусны бүлгийн тохирлоор болон ДНХ-ийн шинжилгээгээр тодорхойлно;

4.1.8.Хөврөл шилжүүлэн суулгах аргаар гарсан төлийн удамшилтыг энгийн аргаар тооцохдоо хөврөл шилжүүлэн суулгасан болон хээлтэгчийн төрсөн үеийн хугацааг тухайн төрлийн малын хээл тээлтийн хугацаа, хөврөлийн настай харьцуулан үзнэ;

4.1.9.Хээлтүүлэгчийн болон арвин ашиг шимт шилмэл малын гарвалийг зөвхөн ДНХ-ийн шинжилгээгээр баталгаажуулна.

4.2.Малын үржүүлгийн мэдээллийг бүртгэх, баталгаажуулах, ашиглах

4.2.1.Бүртгэлийн анхан шатны нэгж буюу сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг болон малын удмын санг хамгаалах асуудал эрхэлсэн байгууллага нь малын үржүүлгийн бүртгэлийг хөтлөхийн тулд энэхүү журмын 4.1.2-д дурьдсан бүртгэл хөтлөгчөөс мэдээллийг цуглуулан бүртгэлийг хийнэ;

4.2.2.Бүртгэл хөтлөгч нь мал үржүүлэгт орсон тухай тэмдэглэгээг тухайн өдөрт нь хувийн тэмдэглэгээ хийх замаар бүртгэж, дараа нь холбогдох маягтын дагуу бүртгэлийн анхан шатны нэгжид мэдээгээ хүргүүлнэ;

4.2.3.Бүртгэлийн тэмдэглэлд хээлтүүлгийн төрөл /ердийн эсвэл зохиомол/, огноо, хээлтэгч, хээлтүүлэгч малын ялган тэмдэглэгээн дэх хувийн дугаар, нэр хоч, зүс, зохиомол хээлтүүлэг хийсэн тохиолдолд техникчийн нэр, код зэргийг бичнэ;

4.2.4.Хөврөл шилжүүлэн суулгасан тохиолдолд донорын болон хээл тээгчийн талаарх мэдээллийг бүртгэнэ;

4.2.5.Малын эзэн, малчин нь шинээр гарсан төлийн хүйс, зүс, эхийн хувийн дугаарыг төллөсөн өдөрт нь тэмдэглэн авч хариуцсан мэргэжилтэн, харьяаллын нэгжид тухайн сардаа мэдэгдэж байна;

4.2.6.Шинээр гарсан төлд 7-30 хоногийн дотор ялгах тэмдэглэгээг хийж, гэрчилгээг шинээр нээнэ;

4.2.7.Зохиомол хээлтүүлгийн бүртгэлийг мэргэжлийн байгууллага, түүний салбар эсвэл малын үржүүлгийн техникч бүртгэлийн нэгжид гаргаж өгөх үүрэгтэй;

4.2.8.Зохиомол хээлтүүлгийн нэгдсэн бүртгэлд гүн хөлдөөсөн үрийг түгээгч байгууллагын код, зохиомол хээлтүүлэгт ашигласан хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хээлтүүлэг хийсэн огноо, техникчийн код, хээлтэгчийн хувийн дугаар, үрийн гуурсны сериал дугаар, зохиомол хээлтүүлэг давтагдсан байдал, хээлийг шалгасан огноо, хээл авалтын байдал зэрэг өгөгдлүүдийг тэмдэглэнэ;

4.2.9.Бэлгийн нэг мөчлөгийн хугацаанд хийсэн зохиомол хээлтүүлэг нийт хэдэн удаа давтагдсаныг бүртгэлийн огноогоор тодорхойлох ба эхний зохиомол хээлтүүлэг 1 гэсэн тоогоор илэрхийлэгдэнэ. Түүнээс хойш давтагдсан байдал нэг нэгээр нэмэгдэн дугаарлагдах ба зохиомол хээлтүүлгийг давхар хийсэн тохиолдолд давтагдсан байдлын тоо өмнөхтэйгээ адил буюу өөрчлөгдөхгүй байна;

4.2.10.Ердийн хээлтүүлгийн талаар бүртгэл хийхдээ хээлтэгчийн үржилд орсон огноо, хээлтэгчийн болон хээлтүүлэгчийн хувийн дугаар, үүлдрийн код, ороо давтагдсан байдал зэрэг өгөгдлүүдийг тэмдэглэнэ;

4.2.11.Үржүүлгийн бүртгэлийг цаасан хэлбэрээр тэмдэглээд дараа нь мэдээллийн сангийн өгөгдөл болгон программд оруулж болно;

4.2.12.Үржүүлгийн тухай өгөгдлийн үнэн зөв эсэхийг бүртгэгдсэн мал тус бүрийн тухай өмнөх өгөгдлийн үзүүлэлттэй харьцуулан шалгаж баталгаажуулна. Тухайлбал, хээлтэгчийн ялгах тэмдэглэгээний хувийн дугаар нь харъяалалтайгаа тохирч байгаа эсэх, хээлтэгч нь үржилд ашиглахад тэнцэхээр насанд хүрсэн эсэх, хээлтэгчийн хээл тээсэн ба ороо орсон хугацаа нь тухайн төрлийн малын физиологийн хугацаатай тохирч байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулна;

4.2.13.Ердийн хээлтүүлгээр үржүүлэгт орсон малын үржүүлгийн тухай бүртгэлийг хянан баталгаажуулахдаа дараах шалгалтыг хийнэ. Үүнд: тухайн малын сүргийн ба үүлдрийн код тохирч байгаа эсэх, хээлтэгч, хээлтүүлэгчийн ялгах тэмдэглэгээний хувийн дугаар харъяалалтайгаа тохирч байгаа эсэх, хээлтэгчийн үржилд орсон ба хээл тээсэн хугацаа тухайн төрлийн мал, амьтны физиологийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулан баталгаажуулна;

4.2.14.Малын үржүүлгийн өгөгдлүүдийг тухайн төрлийн малын төллөлтийн тухай мэдээллийн өгөгдлүүд ирэхээс өмнө бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулсан, дамжуулсан байх ёстой;

4.2.15.Мэдээллийн санд өмнө нь орсон малын үржүүлгийн бүртгэл одоогийн мэдээлэлтэйгээ хэрхэн уялдаж буйг бүртгэгч байнга харьцуулан баталгаажуулж байх ёстой;

4.2.16. Малын үржүүлгийн өгөгдлүүдийг удам зүйн үнэлгээний боловсруулалт хийх зориулалтаар зөвхөн мэргэжлийн байгууллага, баг ашиглана. Энэ тохиолдолд малын тухай мэдээллийг тухайн үнэлгээг гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн Малын бүртгэл, мэдээллийн үндэсний сангаас өгнө;

4.2.17. Малын зохиомол хээлтүүлгийн болон хөврөл үр, түүнийг шилжүүлэн суулгахтай холбоотой бүртгэлийн өгөгдлүүдийг удам зүйн үнэлгээнд ашиглахдаа олон удаагийн цуврал шалгалтанд оруулж баталгаажуулах тул анхан шатны бүртгэгч нар мэдээллийн үнэн зөвийг хариуцах үүрэгтэй;

4.2.18. Удам зүйн үнэлгээг хийхдээ зохиомол хээлтүүлэгт ашигласан хээлтүүлэгчийн ялган тэмдэглэгээний багц код нь Олон улсын кодтой уялдаж байгаа эсэхийг тодорхойлно;

4.2.19. Сүргийн удам зүйн сайжруулалтыг хийхдээ сүргийн болон үүлдрийн кодыг бүртгэлд баримтлах байдлаар явуулж болно;

4.2.20. Үндэсний хэмжээнд хийх малын удам зүйн үнэлгээг мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач нар тодорхой арга зүйн дагуу хийж, үр дүнг олон нийтэд мэдээлсний дараа үнэлгээг албан ёсны гэж үзнэ;

4.2.21. Малын удам зүйн үнэлгээгээр үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч болон түүний үр төлийн тоо, тэдгээрийн сүрэг дэх тархалт, амьдрах чадвар, охин үр төлийн ашиг шимийн удамшилтын хувь зэргийг харьцуулан гаргах ба энэ тухай мэдээллээр малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг баяжуулан шинэчилж байна.

4.3. Малын эрүүл мэндийн байдлыг бүртгэх, баталгаажуулах

4.3.1. Малын эрүүл мэндийн бүртгэлийг энэхүү журмын 3 дугаар хавсралтад тодорхойлсон малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүтцийн 10-12 заалтад дурьдсан үзүүлэлтүүдээр гаргах ба эдгээр өгөгдлүүд нь мэдээллийн нэгдсэн сангийн үндсэн өгөгдлийн үргэлжлэл болно;

4.3.2. Энэхүү журмын 4.3 -д заасан бүртгэлээс гадна Дэлхийн Мал Амьтны Эрүүл мэндийн байгууллагаас заавал бүртгэх өвчний жагсаалтанд байгаа өвчний гаралт, тархалт, түүнтэй тэмцсэн, урьдчилан сэргийлсэн арга хэмжээг бүртгэх, малын өвчин тус бүрт тавигдах эрүүл мэндийн шаардлагыг тодорхойлох ажлыг малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна;

4.3.3. Малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж нь малын эрүүл мэндийн өрхийн дэвтэртэй байх ба малын бүртгэлийн гэрчилгээнд харьяаллын мал эмнэлгийн үйлчилгээний хувийн хэвшлийн нэгжийн мэргэжилтэн, мал бүхий албан байгууллага, аж ахуйн нэгжийн малын эмч холбогдох бүртгэлийг цаг тухай бүрт хөтлөх үүргийг хүлээнэ;

4.3.4. Мал эмнэлгийн үйлчилгээний хувийн хэвшлийн нэгж нь малын эрүүл мэндийн болон мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг тухай бүрт хөтлөх, малын эрүүл мэндтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын гүйцэтгэлийн талаар харьяалалын төрийн

байгууллагын нэгжид сар бүрийн 15-ны дотор тайлагнан, холбогдох бүртгэл тооцоо, мэдээг гаргаж өгөх үүрэгтэй;

4.3.5. Энэхүү журмын 4.3 зүйлд хамаарах бүртгэл, мэдээллийг сум, дүүргийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын мэргэжилтэн хариуцах ба холбогдох мэдээллийг бүртгэлийн нэгдсэн программд оруулан нэгтгэлийг сар бүрийн 20-ны дотор дараагийн шатны байгууллагад хүргүүлж байна;

4.3.6. Аймаг, нийслэлийн ХХААЖДҮГ нь мэдээллийн сангийн тухайн сард баяжуулсан мэдээллийг төв серверт сар бүрийн 25-ны өдрийн дотор онлайнаар, энэхүү журмын 12 дугаар хавсралтад тодорхойлсон маягтаар мал амьтны халдварт өвчний, 13 дугаар хавсралтад тодорхойлсон маягтаар паразиттах өвчний мэдээг бүртгэн дараа сарын 5-ны өдрийн дотор холбогдох албанд тус тус ирүүлнэ;

4.3.7. Мэдээнд баг, хороо, сум, дүүргийн нэрийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стандартын дагуу кодлож, сарын мэдээг тухайн сарын дүнгээр, жилийн эцсийн мэдээг өссөн дүнгээр тус тус мэдээлнэ;

4.3.8. Малын өвчний солбилцолын мэдээллийг уртрагын 7 орон, өргөргийн 6 оронгоор тус тус тэмдэглэн бүртгэж байна;

4.3.9. Малын эрүүл мэндийн бүртгэлийг өвчний ангилал, төрлөөс хамааран ялгавартай хугацаа, холбогдох маягт, программаар дамжуулан бүртгэх ба халдварт өвчний оношийг шинжлэн баталгаажуулсан лаборатори, шинжилгээг хийсэн аргыг бүртгэлд заавал тэмдэглэж байна;

4.3.10. Сар, улирал дамжиж өвчилсөн, түүнээс эдгэрсэн малыг дараа сарын болон улирлын мэдээнд давхардуулж мэдээлэхгүй ба зөвхөн шинээр нэмж өвчилсөн түүнээс эдгэрсэн малыг "өвчилсөн, эдгэрсэн" гэсэн хүснэгтэд бичиж тэмдэглэнэ;

4.3.11. Урьд сарын өвчтэй үлдэгдлээс үхсэн мал байвал тухайн сарын үзүүлэлт дээр нэмж "үхсэн" гэсэн хүснэгтийн нүдэнд мэдээлэх ба энэ тохиолдолд үхсэн малын тоо өвчилсөн малын тооноос илүү байж болно;

4.3.12. Гоц болон архаг халдварт өвчний улмаас зайлшгүй шаардлагаар устгасан, нядалсан малын тоог холбогдох хүснэгтийн нүдэнд бичихдээ том мал, төлөөр ялган бичнэ;

4.3.13. Тухайн мал, сүрэгт хийсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний тарилга, туулгалт, боловсруулалтыг харьяаллын мал эмнэлгийн хувийн хэвшлийн нэгжийн мэргэжилтэн, мал бүхий аж ахуйн нэгжийн малын эмч гардан хийнэ;

4.3.14. Төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээг хийсэн тухай бүртгэлийг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар тодорхойлсон тухайн малын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэж, 10 дугаар хавсралтын маягтаар үйлчилгээ хийсэн нэгтгэлийг хийн малын эзэн, малчнаар баталгаажуулан, хувийг сар бүрийн 15-ны өдрийн дотор харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт хүргүүлж байна;

4.3.15.Энэхүү журмын 4.3.14 дүгээр зүйлд заасан баталгаа нь тус үйлчилгээний төрөл, хэмжээ, хугацаа, хөлсийг тооцох баримт болно;

4.3.16.Тухайн жилд мал, сүрэгт хийх урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалгыг харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт хугацаанд нь хүргүүлж байх үүргийг мал эмнэлгийн хувийн хэвшлийн нэгж, мал бүхий аж ахуйн нэгжийн малын эмч хүлээнэ;

4.3.17.Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь захиалгыг нэгтгэн дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргэх, эм тарилгыг хүлээн авах, хэрэгжилтэнд хяналт тавих, гүйцэтгэлийг бүртгэх, мэдээлэх үүрэгтэй байна;

4.3.18.Үндэсний хэмжээнд хийгдэх малын эпидемиологийн тандах шинжилгээг холбогдох төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага, нэгжийн мэргэжилтэн, судлаач тодорхой арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ;

4.3.19.Тухайн итгэмжлэгдсэн гүйцэтгэгч эпидемиологийн тандалт, шинжилгээний үр дүнгийн тайланг ажлын гүйцэтгэл дуусснаас хойш ажлын 5 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгснөөр уг тандалт шинжилгээг албан ёсны гэж үзнэ;

4.3.20.Эпидемиологийн тандалт, шинжилгээний бүртгэлд дараах төрлийн мэдээллийг багтаана. Үүнд:

- Тандах шинжилгээний зорилго, нэр, хамрах хүрээ, хугацаа, гүйцэтгэгч болон захиалагчийн код;

- Дээжийн нэр төрөл тоо, хэмжээ, дээж сонгосон, авсан аргачлал;

- Дээжинд хамрагдсан малын байршил, хувийн дугаар;

- Шинжилгээ хийсэн арга, оношлуур, цомгийн нэр төрөл, гарал үүсэл, хүчинтэй хугацаа;

- Тандах судалгааны үйл явц, үр дүнгийн мэдээлэл /тухайн өвчний халдварлалтын хувь, тархалт, нөлөөлөгч хүчин зүйлүүд, шинжилгээний дүн/;

- Тандалт шинжилгээний ажлын нийт үр дүн, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж.

4.3.21.Малын зүй бусын хорогдлыг малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн мэргэжилтэн малын эрүүл мэндийн өрхийн дэвтэрт тухай бүрт тэмдэглэж байх үүрэгтэй;

4.3.22.Харьяаллын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтэн эсвэл малын эзэн, малчин зүй бусаар хорогдсон малын бүртгэлийн гэрчилгээг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлийн мэргэжилтэнд сар бүрийн 15-ны дотор хүлээлгэн өгч байх үүрэгтэй;

4.3.23.Гэрчилгээг хүлээн авсан мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлийн мэргэжилтэн зүй бусаар хорогдсон малын бүртгэлийг программд оруулж, бүртгэл мэдээлийн нэгдсэн сангаас холбогдох хасалтыг хийн гэрчилгээг архивлана;

4.3.24.Отрын бүс нутагт зүй бусаар хорогдсон малын тоо, төрлийг малын эзэн, малчин тухай сардаа багтаан орон нутгийн харьяаллын бүртгэлийн нэгжид эсхүл отрын бүс нутгийн захиргаанд мэдэгдэнэ;

4.3.25.Отрын бүс нутагт зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгалын тухай мэдээг харьяаллын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж, сумын мал эмнэлэг, үржлийн тасагт мэдэгдэж байх ба гүйцэтгэлийн байдалд отрын бүс нутгийн захиргаа хяналт тавина.

4.4.Малын ашиг шимийг бүртгэх, баталгаажуулах

4.4.1. Малын төрөл, ашиг шим өгөх онцлогтой уялдан тухайн малын ашиг шимийн бүртгэлийг хийх ба малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өгөгдлийг оруулснаар ашиг шимийн хэмжээ, чанарыг баталгаажуулна;

4.4.2.Малын сүүн болон махан ашиг шимийн бүртгэлийг үржлийн стратегийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага эсвэл мэргэжлийн төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн нэгжүүд гүйцэтгэнэ;

4.4.3.Дээрхи байгууллагууд нь тухайн төрлийн малын ашиг шимийн болон үржлийн ажлын бүртгэлийг гэрээт ажилтнаар дамжуулан хөтлөж болно;

4.4.4.Малын ашиг шимийн болон үржүүлгийн анхан шатны бүртгэлийг хийх гэрээт ажилтны ажлын үүрэг, эрх, хариуцлага, цагийн хуваарь, бүртгэл хийх маягтын загварыг захиалагч гэрээндээ тодорхойлож, энэ чиглэлийн сургалтыг заавал хийсэн байна;

4.4.5.Ашиг шим нь тодорхойлогдохоор бүртгэлд хамрагдаж буй малд энэхүү журмын 2.1.5-2.1.6 зүйлд тодорхойлсны дагуу ялган тэмдэглэгээг заавал хийсэн байна;

4.4.6.Сүүн ашиг шимийг саалийн 100, 150, 305 хоногийн дүнгээр тус тус тооцоолон гаргаж болох боловч малын бүртгэлийн гэрчилгээ болон бүртгэлийн мэдээллийн сангийн нэгтгэл дээр зөвхөн тухайн жилд саагдсан нийт хоногийн саамын өссөн дүн, сүүний тослог, уургийн дундаж хэмжээг тэмдэглэнэ;

4.4.7.Малын махан ашиг шимийг тухайн малын төрөл, ашиг шимийн чиглэл, үүлдэрлэг байдал, тэжээллэг, арчилгаа, маллагааны түвшингээс хамааран туйлын өсөлт, харьцангуй өсөлт, хоногийн нэмэгдэл жин гэсэн үзүүлэлтээр ялгавартай хугацаануудад тодорхойлон тогтооно;

4.4.8.Махан ашиг шимд нарийвчилсан үнэлгээ хийхдээ амьдын жин, нядалгааны жин, нядалгын гарц, гулуузны бүтэц, махны химийн найрлага, илчлэг, дайвар бүтээгдэхүүний анги зэрэг үзүүлэлтүүдийг харгалзана;

4.4.9. Үхрийн махан ашиг шимийг төрөх үеийн жин, хоногийн нэмэгдэл жин, эхээс ялгах үеийн жин, 12, 18 сартай үеийн жин, бордлого эхлэх үеийн жин, бордлогын төгсгөл үеийн жин, нядлагын өмнөх жин, нядлагын гарц, гулуузны жин гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно;

4.4.10. Адууны махан ашиг шимийг нядлагын өмнөх жин, нядлагын гарц, гулуузны жин гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно;

4.4.11. Хонины махан ашиг шимийг нядлагын өмнөх жин, нядлагын гарц, гулуузны жин гэсэн үзүүлэлтүүдээр, бордсон тохиолдолд бордлого эхлэх үеийн жин, бордлогын төгсгөл үеийн жинг тодорхойлно;

4.4.12. Ямааны махан ашиг шимийг нядлагын өмнөх жин, нядлагын гарц, гулуузны жин гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно;

4.4.13. Гахайн махан ашиг шимийг төрөх үеийн жин, хоногийн нэмэгдэл жин, эхээс ялгах үеийн жин, 3-4 сартай үеийн жин, бордлого эхлэх үеийн жин, нядлагын өмнөх жин, нядлагын гарц, гулуузны жин гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно;

4.4.14. Шувууны махлаг байдлыг тодорхойлохдоо биеийн жин, биеийн хэмжээ, булчин махны хөгжилт, өсөлтийн эрчим зэрэг үзүүлэлтүүдийг ашиглах ба өсөлтийн хурдаар нядалгааны хугацааг нь тогтооно.

4.4.15. Энэхүү журмын 4.4.2-д заасан байгууллага нь тухайн малын ашиг шим, түүний чанарыг тодорхойлсон ерөнхий мэдээллийг Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн санд болон Олон Улсын холбогдох байгууллагад сар бүр дамжуулах үүрэгтэй байна;

4.5. Малын шилжилт, хөдөлгөөнийг бүртгэх

4.5.1. Мал, малын эзэн, малчны байршлын бүртгэлээр дамжуулан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт хийх нөхцлийг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын нутаг дэвсгэр дэх малын шилжилт, хөдөлгөөнийг энэхүү журмын дагуу бүртгэнэ;

4.5.2. "Малын хөдөлгөөн" гэсэн ойлголтыг энэхүү журмын хүрээнд малын орлого, зарлагын хөдөлгөөн гэж ойлгоно;

4.5.3. "Малын шилжилт" гэсэн ойлголтыг тухайн мал ямар нэгэн шалтгаанаар харъяаллын нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрт байрших үйл явц гэж ойлгоно;

4.5.4. Тухайн нутаг дэвсгэр дэх малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн малын шилжилт, хөдөлгөөнийг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн нэгжээр дамжуулан тасаг бүртгэж, мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд тухай бүрт оруулж байна;

4.5.5. Малын эзэн, малчин харъяаллаа өөрчлөх, нүүх, бусдад малаа худалдах, бусдаас авах, импортоор оруулж ирэх, экспортонд гаргах тохиолдолд шилжилтийн талаархи мэдээг биеэр, бичгээр эсвэл мэдээллийн технологи ашиглах замаар харъяаллын мал эмнэлэг,

үржлийн нэгж, тасагт ирүүлж, энэхүү журмын 8, 12 дугаар хавсралтад тодорхойлогдсон загвараар баталгаажуулсан гэрчилгээ, тодорхойлолтыг авна;

4.5.6.Тасаг нь малын шилжилттэй холбоотой мэдээллийг ажлын 1 өдөрт багтаан бүртгэл, мэдээллийн санд оруулж, мал шилжин очих газрын бүртгэлийн мэргэжилтэнд дотоод сүлжээгээр урьдчилан мэдэгдэнэ;

4.5.7.Малыг шилжүүлэн авагч тал малын байршил өөрчлөгдсөн тухай тодорхойлолтыг малыг шинээр байршуулсан харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт 14 хоногийн дотор бүртгүүлнэ;

4.5.8.Мал импортлогч нь хилийн хорио цээрийн хяналт дууссан хугацаанаас хойш 30 хоногт багтаан малаа байршуулсан нутгийн харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт энэ тухай мэдэгдэж, нэгдсэн бүртгэлд хамруулна;

4.5.9.Импортлосон малын бүртгэлийг экспортлогч улсаас ирүүлсэн малын гарваль, ашиг шим, эрүүл мэндийн гэрчилгээний тодорхойлолтын эх хувийг үндэслэн хийнэ;

4.5.10.Мал, мах бэлтгэлийн төвлөрсөн цэг, үйлдвэр нь малын бүртгэлийн гэрчилгээ, шилжилт хийсэн тодорхойлолтыг үндэслэн хүлээн авч, харьяалагдах нутаг дэвсгэрийн бүртгэлийн нэгжид хасалтыг хийлгүүлнэ;

4.5.11.Мал, мах бэлтгэлийн төвлөрсөн цэг, үйлдвэрээс бусад газарт хувийн хэрэгцээнд бэлтгэсэн малын талаархи мэдээллээ малын эзэн эсвэл малчин харьяалагдах орон нутгийн мал эмнэлэг, үржлийн нэгж, тасагт биеэр бичгээр эсвэл мэдээллийн технологи ашиглах замаар 30 хоногийн дотор ирүүлнэ;

4.5.12.Малыг экспортолж буй тохиолдолд малын эзэн эсвэл малчин харьяалагдах мал эмнэлэг, үржлийн тасгаар гэрчилгээг баталгаажуулан, хилийн мэргэжлийн хяналтын мал эмнэлэг, хорио цээрийн албанд өгнө;

4.5.13.Цаг агаарын хүндрэлийн улмаас харьяаллын нутаг дэвсгэр дээр өвөлжиж, хаваржих боломжгүй болсон малчин өрх отроор явах малын тоо, төрөл, хаана очих тухайгаа харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт мэдэгдэн сүрэгтээ сумын Засаг даргаар баталгаажуулсан тодорхойлолтыг авна;

4.5.14.Отрын бүс нутагт малын гоц халдварт болон халдварт өвчин гарсан тохиолдолд уг өвчнийг мэдээлэх журмын дагуу тухайн малчин болон харьяаллын малын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн мэргэжлийн байгууллагад болон отрын бүс нутгийн захиргаанд мэдэгдэнэ;

4.5.15.Энэхүү журмын хүрээнд малаа бүртгүүлээгүй малчин өрхийн малын эрүүл мэндийн бүртгэл тодорхойлогдохгүй тул тухайн өрхийг отрын бүс нутагт хүлээн авахгүй;

4.5.16.Отроор ирж байгаа малыг хүлээн зөвшөөрсөн зурвасаар нэвтрэн оруулж байна;

4.5.17.Тухайн отрын бүс нутгийн захиргаа болон орон нутгийн захиргаа шилжилт хөдөлгөөнөөр ирж байгаа мал, сүргийн тодорхойлолтыг үндэслэн бүс нутагт байрших зөвшөөрлийг олгоно.

4.6.Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх

4.6.1.Энэхүү журмын хүрээнд тодорхойлон бүртгэгдсэн мал ор сураггүй алга болох эсвэл хулгайд алдагдсан сэжигтэй байвал малын эзэн 7 хоногийн дотор харъяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт мэдэгдэн малын төрөл, хувийн дугаар, алдагдсан огноог тэмдэглүүлнэ;

4.6.2.Орон нутгийн малын бүртгэлийн мэргэжилтэн уг мэдэгдлийг хүлээн аваад холбогдох мэдээллийг ажлын 1 өдөрт багтаан дотоод сүлжээгээр бусад бүртгэлийн нэгжүүд, төв серверт болон харъяаллын цагдаагийн байгууллагын төлөөлөгчид зарлан мэдэгдэнэ;

4.6.3.Харъяаллын цагдаагийн байгууллагын төлөөлөгч, иргэдээс алдуул болон хулгайлагдсан, олдсон тухай мэдээллийг ирүүлсэн тохиолдолд тухайн мал нь энэхүү журмын дагуу тодорхойлогдон бүртгэгдсэн эсэхийг бүсчлэлийн код бүхий хувийн дугаарт үндэслэн шалгаж, харъяаллынх нь бүртгэлийн нэгжид ажлын 1 өдөрт багтаан дотоод сүлжээгээр мэдэгдэнэ;

4.6.4.Мэдээллийг хүлээн авсан харъяаллын бүртгэлийн нэгж тухайн малын хувийн дугаарын дагуу шалгалт хийж, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байвал эзнийг нь тодорхойлон, бүртгэлд тэмдэглэл хийн, харъяаллын цагдаагийн байгууллагын төлөөлөгчид мэдэгдэнэ;

4.6.5.Алдуул болон хулгайлагдсан малын эзэн, малчин нь уг малаа өөртөө харъяалалтай болохыг нотлох тодорхойлолтыг харъяаллын мал эмнэлэг, үржлийн тасгаас авч болно. Тодорхойлолтыг олгоходоо мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлийг үндэслэнэ.

ТАВ.МАЛЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ

5.1.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, системийн бүрдэл

5.1.1.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь сум, дүүргийн болон аймаг, нийслэлийн мэдээллийн сангаас бүрдэн, компьютер, онлайнд суурилсан бүртгэл, мэдээллийн нэгдсэн программ, сан, сүлжээтэй байна;

5.1.2.Бүртгэл мэдээллийн систем нь биет ба биет бус мэдээллийн хөрөнгөөс бүрдэнэ;

5.1.3.Биет бус мэдээллийн хөрөнгөнд лицензтэй хэрэглээний болон системийн программ хангамж, тэдгээрийг хөгжүүлэх хэрэгслүүд, өгөгдлийн сан, файл, боловсруулалтын мэдээнүүд, электрон архивын материалууд орно;

5.1.4.Биет мэдээллийн хөрөнгөнд компьютер, хэвлэгч, олшруулагч, сүлжээний төхөөрөмж, зөөврийн төхөөрөмж, хэвлэсэн баримт бичгүүд хэрэглэгчийн гарын авлага, сургалтын материалууд хамаарна;

5.1.5.Малыг бүртгэх нэгдсэн системийг дээр дурьдсан хөрөнгөөс гадна доорхи элементүүд бүрдүүлнэ. Үүнд:

- Малыг бүртгэл, мэдээлийн нэгдсэн сан;
- Бүсчлэлийн код бүхий ялган тэмдэглэгээний иж бүрдэл хэрэгслүүд;
- Малыг бүртгэлийн гэрчилгээ;
- Малыг эрүүл мэндийн гэрчилгээ;
- Малыг гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ;
- Шат бүрт тэмдэглэх анхан шатны маягтууд, бүртгэлийн дэвтэр.

5.1.6.Малын бүртгэл, мэдээлийн нэгдсэн сан нь энэхүү журмын 2 дугаар хавсралтаар тодорхойлсон бүтэцтэй байна;

5.1.7.Мэдээлийн нэгдсэн сангийн бүтцийг босоо ба хөндлөнгөөр өргөтгөх тохиолдолд бүтцэд орсон нэмэлт, өөрчлөлтийг журмын хавсралтад оруулж байна;

5.1.8.Мэдээллийн нэгдсэн сан нь энэхүү журмын 5.3.1 - 5.3.3 зүйлд дурьдсан түвшингийн мэдээллийн сангуудтай мэдээлэл солилцох нөхцлийг хангасан байхаас гадна салбарын бусад мэдээллийн сантай зохицож ажилладаг байна;

5.1.9.Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаанд шаардагдах техник хэрэгсэл, программ хангамж, сүлжээ, тэдгээрийн үйлчилгээний зардлыг улсын төсөв, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, мал бүхий иргэдийн санхүүжилтээс гаргана.

5.2.Бүртгэл мэдээллийн санд өгөгдлийг бүрдүүлэх, хүлээн авах, хадгалах

5.2.1.Малын бүртгэл, мэдээллийн сангийн дэд бүтэц тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн программ хангамжид гараас болон уншигчаас оруулах замаар баяжуулж байна;

5.2.2.Мэдээллийн сангийн баяжилтыг бүх шатны бүртгэгч нар гүйцэтгэн, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж байна;

5.2.3.Мэдээллийг шинээр болон нэмж оруулах, засварлах, харах, хэвлэх үйлдлүүд линкээр дамжин гүйцэтгэгдэх ба бүртгэгчийн оруулаагүй мэдээллийг программын систем өөрөө хайж анхааруулга өгч байхаар программчлагдана;

5.2.4.Мэдээллийн сангаас хайлт хийхэд хялбар болгон өгөгдөлүүдийг дор дурьдснаар төрөлжүүлнэ. Үүнд:

а/аймаг, сум, багийн бүсчлэлийн кодоор;

б/эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр;

в/малын хувийн дугаараар;

г/малын эзэн, малчны кодоор гэх мэт.

5.2.5.Мэдээллийг батлах өгөгдлүүд нь мэдээллийн бүрэн бүтэн байдал, уялдаа холбоо, өгөгдлүүдийн магадлалд ямар алдаа дутагдал илэрч байгааг тооцох шалгуурыг хангаж байна;

5.2.6.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг нийтийн мэдээлэл, байгууллагын нээлттэй дотоод мэдээлэл, байгууллагын итгэмжлэгдсэн дотоод мэдээлэл, нууц мэдээлэл гэсэн ангилал бүхий мэдээллүүд бүрдүүлнэ;

5.2.7.Нийтэд зориулсан, ямар нэг хязгаарлалт хийгдээгүй, нууцлах шаардлагагүй, буруугаар ашиглан байгууллагад ямар нэгэн хохирол учруулах боломжгүй хувилах, хадгалах, дамжуулахад ямар нэгэн шаардлага тавихгүй мэдээллийг нийтийн буюу ангилалд орохгүй мэдээлэл гэж үзнэ;

5.2.8.Байгууллагын дотоод журам, заавар, утасны жагсаалт, электрон шуудангийн хаяг, дотоод зарлал гэх мэт байгууллага дотроо хувиран олшруулж тараахад хязгаарлалт тавихгүй боловч байгууллага дотроо ашиглах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хянаж, ангиллын зэрэглэлээр хаяглах, гадны хандалтаас хамгаалагдсан мэдээллийг байгууллагын нээлттэй дотоод мэдээлэл гэж үзнэ. Энэ төрлийн мэдээллийг нийтийн сүлжээгээр дамжуулах бол заавал кодлох ба эх мэдээлэл байгууллагад архивлагдан үлдэнэ. Мэдээллийн төв сангаас зөвшөөрсөн тохиолдолд энэ төрлийн мэдээллийг гадны хамтран ажиллагч нарт дамжуулна;

5.2.9.Хариуцах тодорхой эрх бүхий хүнээс зөвшөөрөл авч хязгаарлагдмал эрхтэйгээр хандаж болох байгууллагын дотоод мэдээллийг итгэмжлэгдсэн дотоод мэдээлэл гэнэ. Санхүүгийн мэдээ, даргын тушаал, тогтоол, архивын материал, албан бичиг, өдөр тутмын ажлын баримт бичиг, хурлын протокол зэрэг нь энэ төрлийн мэдээлэлд багтана. Энэ төрлийн мэдээллийг шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авч хариуцсан хүнээр хувилуулах ба хувилах хэмжээ нь тухайн мэдээллээс шалтгаалж хязгаарлагдмал байна. Энэ төрлийн мэдээлэлд зөвшөөрөлгүй хандан өөрчлөхөөс хамгаалагдан тохируулгыг программд хийнэ. Мэдээллийг нийтийн сүлжээгээр электрон хэлбэрээр дамжуулах бол заавал кодлох ба эх мэдээлэл байгууллага дотор үлдэнэ. Гадны хамтран ажиллагч нарт зөвхөн эрх бүхий хүний зөвшөөрсөн мэдээллийг дамжуулж болно;

5.2.10.Гадны хандалт, халдалтаас хамгаалагдсан,электрон хэлбэрээр хадгалахдаа нууц үгтэйгээр кодлон хадгалдаг, тусгай хаягтай, тодорхой тооны эрх бүхий албан тушаалтан

нууц үгээр нэвтэрдэг мэдээллийг нууцын ангиллын мэдээлэл гэж үзнэ. Энэ төрлийн мэдээллийг зөөврийн төхөөрөмжинд хуулбарлах, хувиран олшруулахгүй. Нууцын ангиллын цаасан мэдээллийг хадгалж байгаа шүүгээ нь цоожтой, компьютер нь физик хамгаалалттай өрөөнд байна. Зөвхөн нууцын журамд заагдсан эрх бүхий этгээдэд шаардлагатай тохиолдолд мэдээллийг дамжуулж болно. Мэдээллийг дамжуулахдаа нууц үг хэрэглэх ба шуудангаар дамжуулах тохиолдолд нууцын батламжийг хийлгэнэ;

5.2.11.Мэдээллийг зэрэглэл, төрлөөр нь ангилан хаяглах ба мэдээллийн ангилал, агуулгыг цаасан баримтын эхний хуудсанд, зөөгч төхөөрөмжийн гадна талд бичин архивлаж байна;

5.2.12.Мэдээллийг нууцлах, ашиглах, хадгалах хугацаа дууссан бол файл, цаасан баримт, хуучин CD зэргийг удирдлагын зөвшөөрлийн үндсэн дээр ажлын хэсэг гарган устгана.

5.3.Мэдээллийн сангаас өгөгдлийг дамжуулах

5.3.1.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан буюу төв серверт дараахь байгууллагууд мэдээлэл нийлүүлнэ. Үүнд:

- Аймгийн ХХААЖДҮГ-ийн албадууд;

- Мал эмнэлгийн болон малын үржлийн ажил, үйлчилгээ эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага;

- Мэргэжлийн холбоод;

5.3.2.Аймаг, нийслэлийн малын бүртгэл, мэдээллийн санд харьяаллын мал эмнэлэг, үржлийн тасгууд мэдээлэл нийлүүлнэ;

5.3.3.Сум, дүүргийн малын бүртгэл, мэдээллийн санд дараахь нэгж мэдээлэл нийлүүлнэ. Үүнд:

- Харьяаллын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүд;

- Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжүүд;

5.3.4.Малын бүртгэл, мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч нар нь холбогдох мэдээллийг графикт хугацааны дагуу үнэн зөв гаргаж цахим хэлбэрээр ирүүлж байна;

5.3.5.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан нь үүрэг хариуцлага, эрх мэдлийнхээ хүрээнд энэхүү журмын 5.3.1-5.3.3-д заасан нэгж, байгууллагын алинаас нь ч шаардлагатай мэдээллийг нэмж авч болно;

5.3.6.Малын удам гарваль, ашиг шим, эрүүл мэнд, шилжилт, хөдөлгөөний тухай улсын доторхи мэдээллийг бүртгэлийн нэгжээс зөвшөөрөгдөх хэмжээнд холбогдох байгууллагад дамжуулж байна;

5.3.7.Малын ашиг шим, эрүүл мэндийн тухай мэдээ, мэдээллийг олон улсын байгууллагад зөвхөн эрх бүхий байгууллагын даргын зөвшөөрлийн үндсэн дээр зохих журмын дагуу хүргүүлнэ;

5.3.8. Сүлжээний компьютерүүд албан ёсоор зөвшөөрөгдсөн интернет гарцаар холбогдож, цахим шуудангаар файл дамжуулахад шифрлэх, архивлах технологийг ашиглаж байна;

5.3.9.Шаардлагатай төрийн байгууллага, аж ахуйн нэгж, хэрэглэгчдэд лавлагаа мэдээлэл хүргэх ажлыг малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас гүйцэтгэнэ;

5.3.10.Бусад мэдээллийг дамжуулах, авах зарчмыг тусгайлсан заавраар зохицуулна.

ЗУРГАА.БҮРТГЭЛЭЭР ДАМЖУУЛАН ХЯНАЛТ ХИЙХ ТУХАЙ

6.1.Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэх

6.1.1.Малын эзэн, малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, малчин өрх бүр бүртгэлийн нэгдсэн системд байршлаараа тодорхойлогдон бүртгэгдэнэ;

6.1.2.Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн бүртгэлийг эхлээд нэг удаа хийх ба явцын бүртгэлийг ялгавартай хугацаагаар, шилжилт, хөдөлгөөнийг тухай бүрт нь бүртгэж байна;

6.1.3.Энэхүү журмын 2.1.4-д заасны дагуу тодорхойлогдон бүртгэлд орсон малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийг харьяалагдах нутаг дэвсгэрийн мал эмнэлэг, үржлийн тасгаас бүртгэлийн код буюу таних дугаараар бүртгэнэ;

6.1.4.Бүртгэлийн дугаарыг аймаг, сум, багийн код, баг дотор нь 01-1000 хүртэл дугаарласан Үндэсний статистикийн газрын өрхийн кодыг ашиглах замаар давхардуулахгүйгээр кодлоно;

6.1.5.Малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн код нь малын ялган тэмдэглэгээний хэрэгсэл дээр бичигдэхгүй бөгөөд энэхүү журмын 4.1.18-д тодорхойлогдсон бүртгэлийн баримт бичгүүд болон бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тэмдэглэн хэрэглэгдэнэ;

6.1.6.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл бүхий малын эзэн, малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж нь энэхүү журмын 11.1.4-д заагдсны дагуу олгогдсон тусгай код буюу таних дугаар бүхий тэмдгийг хэвлүүлж, журмын 4.1.18 -д тодорхойлогдсон бүртгэлийн баримт бичгүүдийн бэлтгэн нийлүүлэгчтэй холбогдолтой хэсэг дээр дарж баталгаажуулдаг байж болно.

6.2.Малын бүртгэлийн гэрчилгээ, бүртгэлийн маягтуудыг хөтлөх

6.2.1.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд малд "Малын бүртгэлийн гэрчилгээ", малын гаралтай бүтээгдэхүүнд "Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ"олгоно.

6.2.2.Энэхүү журмын 3 дугаар хавсралтаар тодорхойлогдсон, тухайн төрлийн малын амьдралын хугацааны онцлог чанарыг бүртгэлээр дамжуулан ялган тогтооход шаардагдах мэдээллийг багтаасан албан ёсны гэрчилгээг тухайн малын бүртгэлийн буюу гарал үүслийн гэрчилгээ гэж үзнэ.

6.2.3.Малын бүртгэлийн гэрчилгээний дугаар нь тухайн малын ялган тэмдэглээний дугаартай ижил байна.

6.2.4.Малын бүртгэлийн гэрчилгээ нь хуурамчаар хэвлэх боломжгүй, өндөр зэрэглэлийн нууцлалтай, тухайн малын хувийн дугаарыг зураасан кодоор давхар илэрхийлсэн, нэгдсэн журмаар хэвлүүлсэн үнэт цаасан баримт байна;

6.2.5.Нэг стандартын хувийн дугаараар ялган тэмдэглэгдсэн малд журмын 6.2.1-6.2.3-д дурьдсан гэрчилгээг олгох ба үржлийн болон товарын малын бүртгэлийн гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд батлана;

6.2.6.Малын бүртгэлийн гэрчилгээг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь гэрээ байгуулсан үйлчилгээний нэгжээр дамжуулан малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжид олгож байна;

6.2.7.Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтэн нь харьяалагдах малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн малд ялган тэмдэглээ хийх үед дээрхи бүртгэлийн гэрчилгээг олгох ба гэрчилгээний дугаар ялган тэмдэглэх хэрэгсэл дэх дугаартай ижил байгаа эсэхийг тогтмол хянаж байх ёстой;

6.2.8.Бүртгэлийн гэрчилгээн дэх тэмдэглэгээнүүдийг тухайн малд мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ үзүүлсэн, ангилалт хийсэн мэргэжилтэн тухай бүрт нь хийж байх үүрэгтэй;

6.2.9.Малын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд малын эзэн, малчин харьяаллын мал, эмнэлэг үржлийн тасаг, үйлчилгээний нэгжид 14 хоногийн дотор мэдэгдэж, гэрчилгээг нөхөн авах хүсэлтээ гаргах ба холбогдон гарах зардлыг өөрөө хариуцна;

6.2.10.Малын бүртгэлтэй холбоотой хөтлөх маягтын загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд баталж, энэхүү журмын хавсралтаар нэмэлт, өөрчлөлтийг оруулж байна;

6.2.11.Маягт тус бүрийг хөтлөх зааварчилгааг малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас өгч байна.

6.3.Мал, түүний гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах

6.3.1.Энэхүү журмын дагуу 2.1.1, 2.1.4, 2.1.6, 2.1.19, 4.1.3, 4.3.1, 4.3.14, 4.5.5, 6.2.1 зүйлд заасны дагуу тодорхойлогдон бүртгэгдээгүй эсвэл бүртгэлийн болон эрүүл мэндийн гэрчилгээгүй мал, түүний гаралтай бүтээгдэхүүнийг "гарал үүсэл нь тодорхойгүй" гэж үзнэ;

6.3.2.Малын гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн болон малын эрүүл мэндийн гэрчилгээг нутаг дэвсгэрийн харъяаллын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн малын эмч тухай бүрт холбогдох зааврын дагуу олгож байна;

6.3.3.Малын гаралтай түүхий эдийг журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу кодлох ба кодын сүүлийн 2 орон нь тухайн түүхий эдийн үндсэн код болно;

6.3.4.Гарал үүсэл нь тодорхойгүй мал, түүний гаралтай бүтээгдэхүүнийг биржээр худалдах, урамшуулал олгох боломжгүй болно;

6.3.5.Энэхүү журмын 6.3.1, 6.3.2 дугаар зүйлд заасны дагуу гарал үүсэл нь тодорхойлогдоогүй мал, түүний гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, цехэд хүлээн авахгүй;

6.3.6.Өөрийн өмчлөл, эзэмшлийн малын шилжилт хөдөлгөөний тухай мэдээллийг орон нутаг дахь мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжид тогтоосон хугацаанд өгөхөөс татгалзсан малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжид аливаа төрлийн дэмжлэг үзүүлэхээс татгалзаж болно;

6.3.7.Энэхүү журмын хүрээнд сум, дүүрэг, аймгийн бүртгэлийн мэргэжилтэн нь малын анхан шатны мэдээллийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд үнэн зөв оруулах, дамжуулах үүргийг гүйцэтгэх ба харъяаллын нутаг дэвсгэрийн малын гарал үүслийн бүртгэлийн үнэн зөвийг батлан тодорхойлсон дүгнэлтийг өгөх, шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох, энэхүү журамтай холбоотой бусад заалтуудыг хэрэгжүүлэх эрх, үүрэгтэй байна;

6.3.8.Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь өмчлөлийн малд ялган тэмдэглэгээ хийлгэж нэгдсэн бүртгэлд хамруулах, үржлийн ажил үйлчилгээ, эрүүлжүүлэх арга хэмжээг явуулах зэрэгт мэргэжилтэнд туслалцаа үзүүлэх, малын шилжилт, хөдөлгөөнтэй холбогдолтой бүртгэлийг хөтлөн харьяалагдах сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжид мэдэгдэх, малын тодорхойлолт болон бүртгэлд зарцуулагдах төлбөрийг хариуцах, түүнчилэн Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд болон энэхүү журамд тусгагдсан мал аж ахуй эрхлэгчтэй холбогдолтой бусад заалт, тогтоолыг дагаж мөрдөнө;

6.3.9.Мал худалдан авагч болон борлуулагчид нь мал худалдан авсан болон худалдсантай холбоотой мэдүүлгийг харьяалагдах сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн нэгж, тасагт мэдэгдэн, холбогдох тодорхойлолтыг авна;

6.3.10.Махны үйлдвэр, мал, мах бэлтгэлийн төвлөрсөн цэг нь энэхүү журмаар тодорхойлогдсон малыг нядалгаанд хүлээн авах ба гэрчилгээгүй эсвэл хуурамч гэрчилгээтэй нь илэрсэн малыг нядалгаанд оруулахгүй, энэ тухай холбогдох байгууллагад мэдээлж болно;

6.3.11.Махны үйлдвэр, мал, мах бэлтгэлийн төвлөрсөн цэгийн малын эмч тухайн малын бүртгэлийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолтыг үндэслэн нядалгаанд орсон малын гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажсан гэж үзэж болно;

6.3.12.Энэхүү журмын дагуу тодорхойлогдож, нэгдсэн санд бүртгэгдээгүй малын гарал үүслийг тодорхойгүй гэж үзэх тул тухайн нутаг дэвсгэрийн мал эмнэлэг, үржлийн тасгаас малын эзэн мал нь нэгдсэн бүртгэлд орсон эсэх талаар тодорхойлолтыг заавал авна;

6.3.13.Махны үйлдвэр, мал, мах бэлтгэлийн төвлөрсөн цэгийн малын эмч бэлтгэлд орсон малын тоо, төрөл, хүлээн авсан огноог харъяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт 21 хоногт тутамд заавал мэдээлнэ.

ДОЛОО.БҮРТГЭЛИЙН АЖЛЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

7.1.Малыг бүртгэх ажлын үүрэг, хариуцлага

7.1.1.Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бүрдүүлэхтэй холбогдсон журам, заавар, бүртгэлийн гэрчилгээ болон маягтын загварыг батлах, малыг ялган тэмдэглэх хэрэгслийн төрөл, түүнд бичигдэх сериал дугаарыг тогтоох, бүртгэлийн нэгдсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих үүргийг төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ;

7.1.2.Энэхүү журмын хүрээнд малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн санг бүрдүүлэх, төв сервер, сүлжээг бий болгох, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах, холбогдох төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагаас мэдээлэл хүлээн авах, дамжуулах үүргийг төрийн захиргааны байгууллага хариуцна;

7.1.3.Төрийн захиргааны байгууллага нь орон нутгийн захиалгад үндэслэн тухайн жилд шаардагдах малыг ялган тэмдэглэх хэрэгслийн тоо хэмжээг баг тус бүрээр гаргах, захиалах, хүлээн авах, хүргэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, шаардлагатай зардлын төсвийг төлөвлөх үүрэгтэй байна;

7.1.4.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн санд шат шатны мэдээллийн санг бий болгох, баяжуулах, тэдгээрийн мэдээллийн солилцооны хэвийн байдлыг хангах, доголдлыг арилгах, мэргэжил, арга зүйгээр хангах зэрэг чиг үүргийг төрийн захиргааны байгууллага хүлээн холбогдох хариуцлагыг шат шатны бүртгэгч нартай тооцно;

7.1.5.Мал эмнэлгийн болон малын үржлийн ажил, үйлчилгээ эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод нь хариуцсан чиглэлийн нарийвчилсан бүртгэлийг хийх, үйлчилгээ үзүүлэх, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх, баяжуулах, малын удам зүйн үнэлгээг хийх, зөвлөмж гаргаж болно;

7.1.6.Аймаг, нийслэлийн ХХААЖДҮ-ийн газар нь малын бүртгэл, мэдээллийн санг сум, дүүргээс ирүүлсэн мэдээгээр баяжуулан, нэгтгэлийг сар бүрийн 25-нд төв серверт ирүүлэх үүрэгтэй байна;

7.1.7.Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь харъяаллын нутаг дэвсгэр дэх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн болон тэдгээрийн өмчлөл дэх малын удам гарваль, ашиг

шим, эрүүл мэнд, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ, шилжилт, хөдөлгөөний талаар анхан шатны мэдээллийг үйлчилгээний нэгжтэй хамтран цуглуулж, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн программ хангамжид оруулах, мэдээллийн санг бий болгох, тухай бүрт баяжуулах, хасалт хийх үүргийг хүлээнэ;

7.1.8.Тасаг нь мэдээллийн нэгдсэн санд орсон өөрчлөлтийн талаар мэдээг сар тутмын 20-нд аймаг, нийслэлийн ХХААЖДҮ-ийн газарт хүргүүлж байна;

7.1.9.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан нь энэхүү журмын 2.5-д заасны дагуу нийлүүлэгдсэн ялган тэмдэглэгээний хэрэгсэл болон бүртгэлийн гэрчилгээ, холбогдох бүртгэлийн маягтуудыг аймгийн ХХААЖДҮ-ийн газраар дамжуулан сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасагт, тасаг нь гэрээ байгуулан ажиллаж буй мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжид хүргүүлж байна;

7.1.10.Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж нь нийлүүлэгдсэн ялган тэмдэглэгээний хэрэгслийг хариуцсан баг, дүүргийн малчин өрх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн малд байршуулан, бүртгэлийн гэрчилгээг бичиж, малын эзэн эсвэл малчинд хүлээлгэн өгөх ба үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэгээг тухай бүрт гэрчилгээнд хийж, мэдээг сар бүрийн 15-нд харъяаллын мал эмнэлэг, үржлийн тасагт өгөх үүрэгтэй;

7.1.11.Энэхүү журмын 5, 6, 10 дугаар хавсралтаар тодорхойлогдсон маягтыг мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн, 8, 9, 11 дүгээр хавсралтаар тодорхойлогдсон маягтыг сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн холбогдох ажилтан, 12 дугаар хавсралтаар тодорхойлогдсон маягтыг ангилалт хийсэн мэргэжилтэн тухай бүрт хөтлөж, баталгаажуулсан хувь, мэдээг сум дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасагт архивлан хадгалж байна;

7.1.12.Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, малын эзэн, малчин нь өөрийн өмчлөл, эзэмшлийн малд ялган тэмдэглэгээ хийлгэх, нэгдсэн бүртгэлд хамруулах, холбогдох анхан шатны хувийн тэмдэглэгээ (малын төрсөн огноо, хүйс, зүс, хувийн дугаар, үржүүлгийн болон төрөлтийн байдал, мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдсан байдал, шинэ төл нэмсэн, худалдан авсан, борлуулсан, шилжүүлсэн, шилжиж ирсэн, зүй бусаар хорогдсон, нядалсан хугацааны тухай)-г хийж мэдээлэл өгөх зэргээр мал, түүний гаралтай бүтээгдэхүүний гарал үүслээ баталгаажуулах үүрэгтэй байна;

7.1.13.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн программ хангамж дээр ажиллах ажилтнууд мэдээллийг ангилах, мэдээллийг хаяглах, дамжуулах мэдлэгийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай;

7.1.14.Бүртгэгч нь интернетэд холбогдон ажиллах программ, ашиглахыг хориглосон программын жагсаалтыг дагаж мөрдөх ба сүлжээний хэрэглэгч гадны компьютерыг дотоод сүлжээнд холбохыг эрс хориглоно;

7.1.15.Бүх шатны бүртгэл хариуцсан нэгж нь мал ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх асуудлаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, ажлын явцын талаар графикт хугацаанд тайлагнах үүрэгтэй байна.

7.2.Бүртгэгчийн үүрэг, хариуцлага

7.2.1.Энэхүү журмын хүрээнд малын бүртгэл, мэдээллийн системд хамгийн өндөр эрхтэй оролцогч нь сүлжээний болон мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулагч буюу администратор байна;

7.2.2.Сүлжээний зохицуулагч нь тухайн сүлжээний тохиргоо, удирдлагыг зохицуулах, найдвартай үйл ажиллагааг хангах, хянах, дэд системд хуваарилалт хийх, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, удирдах, дотоод сүлжээ ашиглагчийг бүртгэх, сүлжээнд нэвтэрч байгаа хэрэглэгчдийн хандах эрх, ажиллах түвшинг тодорхойлох, системийн архивыг бүрдүүлэх, эвдэрсэн мэдээллийг сэргээх зэргээр дотоод болон алсын сүлжээний удирдлага, бүтцийг тодорхойлж, шаардлагатай бүх үйлчилгээ, тохируулгын ажлыг гардан хийх үүрэгтэй байна;

7.2.3.Мэдээллийн сангийн зохицуулагч нь нэгдсэн программ, түүнд суусан мэдээллийн /DATABASE/ сангийн үйл ажиллагааг удирдах, үйлчилгээ хийх, мэдээллийн сангийн хэрэглэгчид тэдгээрийн хандалтын эрхийн хэм хэмжээг тогтоох, мэдээллийн санг архивлах, ашиглалтын үед гарсан аливаа асуудлыг шийдэх, мэдээллийн сангийн дэд систем болон мэдээллийг сэргээх, мэдээллийн сангийн бүртгэгч нарт зөвөлгөө өгөх зэрэг ажлыг хариуцна;

7.2.4.Системийн техник хангамж, программ хангамж, сүлжээ ба харилцаа холбооны системд физик халдлага болон сүлжээний зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалагдсан тохиргоог заавал хийсэн байна;

7.2.5.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээний ажилд шаардлагагүй, мэдээллийн нууцлалд нөлөөлж болох, лицензгүй программуудыг сүлжээнд ашиглахыг зөвшөөрөхгүй;

7.2.6.Сүлжээний болон мэдээллийн сангийн зохицуулагчдаас бусад сүлжээ ашиглагчдыг бүртгэгч ба энгийн хэрэглэгч гэсэн 2 эрхээр бүртгэнэ;

7.2.7.Мэдээллийн сангийн бүртгэгч нь дотоод сүлжээнд хэрэглэгч (user) эрхээр бүртгүүлэх бөгөөд өдөр тутмын мэдээлэл оруулах, үр дүн гаргах, мэдээллээ архивлах, хэрэгцээний мэдээ тайланг авах, дамжуулах зэрэг тухайлсан үйл ажиллагаанд хандаж харьцаж байх урьдчилан тогтоогдсон хязгаарлагдмал эрхтэй ажиллана;

7.2.8.Энгийн хэрэглэгчид нь системийн серверт үйлчлүүлэгч /Client/ болж холбогдоно;

7.2.9.Малын бүртгэл, мэдээллийн системд төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн нэгдсэн программ хангамжийг хэрэглэнэ;

7.2.10.Малын бүртгэл, мэдээллийн санд оруулсан анхан шатны өгөгдлийг аль ч түвшний ямар ч бүртгэгч өөрчлөх эрхгүй;

7.2.11.Хэрэглэгч бүр өөрийн байгууллагын дотоод сүлжээнд нэвтрэх нэр, нууц үгтэй байх бөгөөд нэвтрэх нэр, нууц үгээ бусдад ямар нэгэн хэлбэрээр дамжуулах, системийн нууц үг

шалгагч програмыг ажиллуулах, системд өөр эрх ашиглан нэвтрэх, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр ажлын байрнаас компьютерийг гадагш гаргах, бусдын компьютерийг зөвшөөрөлгүй ашиглах, файлыг нээх, өөрийн болон бусдын компьютерийн firewall, вирусны эсрэг программыг идэвхгүй болгох, компьютераар хууль бус үйлдэл хийх, ажлаас халагдсан, гарсан тохиолдолд байгууллагын мэдээллийг бусдад тараахыг хориглоно;

7.2.12.Шинэ системийг нэвтрүүлэх, суурилуулах, ашиглах, мэдээллийн системд учирч болох аливаа эрсдлээс сэргийлэх сургалтыг төв сервер буюу Малын бүртгэл, мэдээллийн Үндэсний сан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жилд 1-2 удаа бүртгэлийн мэргэжилтэн нарын дунд зохион байгуулж байна;

7.2.13.Сүлжээний бүх хэрэглэгч вирусны эсрэг программаа шинэчилж байх, электрон шууданд хавсран ирсэн файлын вирусыг тогтмол шалгах, эх сурвалж тодорхойгүй ирсэн файлыг нээж үзэхгүйгээр устгах, зөөврийн диск, төхөөрөмжид хандахаас өмнө вирусыг заавал шалгаж байх, электрон мэдээлэл, программ хангамжтай ажиллахдаа файлыг нөөцлөн хадгалах үүрэгтэй байна.

7.3.Мэдээллийн сан, программ хангамж, сүлжээний нууцлалыг хадгалах

7.3.1.Малын бүртгэл, мэдээллийн сан, түүний хөрөнгийг малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сангийн эрхлэгч хариуцаж, мэдээллийн нууцлал хамгааллыг зэрэглэлээр нь ангилна;

7.3.2.Малын бүртгэл, мэдээллийн үндэсний сангийн эрхлэгч нь ямар мэдээлэлд хэн ямар эрх, үүрэгтэй хандах, хариуцах ерөнхий чиг үүргийг тодорхойлно;

7.3.3.Системийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, нууцлал хамгааллыг системийн зохицуулагч хариуцаж, хадгалагдаж байгаа мэдээллийг нууцлал хамгааллын зэрэглэлээр нь зааж хаяглах, мэдээллийн нууцлалын шинэ технологийг цаг алдалгүй байгууллагадаа нэвтрүүлэх, орон нутгийн бүртгэлийн мэргэжилтэнд мэдээллийн нууцлалын талаар танилцуулга хийж байх үүргийг хүлээнэ;

7.3.4.Шат, шатны бүртгэлийн мэргэжилтэн нь өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж, боловсруулж байгаа мэдээллийн эзэмшигч, үнэн зөвийг хариуцагч байж, нууцыг чандлан хамгаалах үүрэгтэй;

7.3.5.Бүртгэлийн мэргэжилтэн ажлаас урт хугацааны чөлөө авах, хөдөлмөрийн гэрээ цуцлах үед эзэмшиж байсан компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж, зөөврийн төхөөрөмж, электрон байдлаар хадгалагдсан мэдээллүүд, хэвлэсэн баримт бичгүүд, нэвтрэх карт, гарын авлага зэрэг байгууллагын мэдээллийн хөрөнгийг мэдээллийн сангийн ерөнхий зохицуулагчид мэдэгдэн, зөвшөөрөл өгсний дараа хүлээлгэн өгөх үүрэгтэй байна;

7.3.6. Мэдээллийн сангийн зохицуулагч тус мэргэжилтний системд нэвтрэх нэр, кодыг хаах, шинэ ажилтанд зөвшөөрөл олгох, тэмдэглэгээ файлд ажилтны нууц үгийг хадгалахгүй байх,

тэмдэглэгээ файлыг боловсруулах программд хууль бусаар өөрчлөлт орохоос хамгаалах ажлыг мөн гүйцэтгэнэ.

7.4.Малыг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах ажлын бусад үүрэг, хариуцлага

7.4.1.Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх үүргийг дараахь шатны төрийн байгууллага хариуцна:

-сум, дүүргийн мэдээллийн санг тухайн шатны Засаг даргын дэргэдэх мал эмнэлэг, үржлийн тасаг;

-аймаг, нийслэлийн мэдээллийн санг тухайн шатны Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар;

-үндэсний нэгдсэн санг мал эмнэлэг үржлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

7.4.2.Энэхүү журмын хэрэгжилтэнд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан, бүх шатны мал эмнэлэг, үржлийн байгууллага тус тус дотоод хяналт тавина;

7.4.3.Энэхүү журамд нарийвчилан тодорхойлсноос бусад малын нэгдсэн бүртгэлтэй холбоотой үүрэг, хариуцлага нь холбогдох хуулийн харилцаагаар зохицуулагдана.